

2023 оны 5-р сарын 15

Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс

И-мэйл: communications@amcham.mn

Утас: +976 99091557

Веб: <https://amcham.mn/publications/1>



АмЧам Монголын гишүүн байгууллагууд дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлтийн нөлөөг бууруулах Service Day 2023 эвентийг амжилттай зохион байгуулав



УЛААНБААТАР ХОТ, Монгол Улс – Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол) 2023 оны 5-р сарын 13-ны өдөр “Service Day 2023” үйл ажиллагааг гишүүн байгууллагуудын хамтаар амжилттай зохион байгуулав. Жил бүрийн 5-р сарын хоёрдугаар долоо хоногт орон даяар мод тарих аяны хүрээнд АмЧам Монгол ТББ-ийн Компанийн нийгмийн хариуцлагын хорооны санаачлагаар мод тарих ажлыг зохион байгуулдаг ба энэ жил хоёр дахь удаагаа үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 80 гаруй төлөөлөгч, 3 дэмжигч байгууллагын хамтаар 200 ширхэг агч мод тариалав.



Service Day бол дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлтийн нөлөөг бууруулах үйл хэрэгт 70 гаруй гишүүн байгууллагуудын хамт олонг уриалж, ногоон байгууламжийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа юм. АмЧам Монгол нь хувийн хэвшлийн дуу хоолойг нэгтгэхийн зэрэгцээ тэдний нийгмийн хариуцлагын хүрээнд олон нийтийн төлөө ажлуудыг зохион байгуулдаг.

Бидний үйл хэргийг дэмжсэн Барловоурлд Монголиа, Хербалайф Монголиа, Орифлэйм Монголиа байгууллагуудад чин сэтгэлийн талархлыг илэрхийлж байна.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн Ази Номхон далайн 29 орны Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.